

БАТЛАВ,  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.БАТЦЭЦЭГ

МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР "ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
"ДОТУУР БАЙРНЫ ОР, ТАВИЛГА" ХУДАЛДАН АВАХАД ТАВИГДАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2024.02.27

№	Тоног төхөөрөмж	Дараах техникийн үзүүлэлт хангасан (эсхүл түүнтэй дүйцэх)	Тоо ширхэг
1	Дотуур байрны давхар ор	Амрах зориулалт бүхий төмөр ор нь давхарлан угсрагдах боломжтой давхар ор байна. Орнууд нь урд талаараа хамгаалалттай, дээд давхарт гарах шатны хэмжээ L1170мм x W350мм гишгүүр хоорондын зай 150мм байхаар тооцож шатыг орнуудын баруун гар талын хэсэгт үндсэн урт рам хэсэгт боож тогтоосон байна. Орны толгой болон хөлний төмөр хийцийг бөөрөнхий яндан хоолой төмрөөр хийж гагнаасан холбоостой байх ба урд хэсгийн 2 талын тууш хэсэг болон шатны хэсгийг профиль квадрат төмрөөр тус тус хийсэн байна. Төмөр орны хөлнүүдийн шалтай харьцах хэсэгт ус чийгнээс хамгаалах тохирсон PVC тагтай байна. Төмөр орыг угсрах, угсрагдах ажлын зураг, иж бүрдлийн жагсаалт, дагалдах ээлбэг хэрэгсэл болон зөөвөрлөж тээвэрлэхэд зориулагдсан хамгаалалтын баглаа боодолтой байна. Давхар төмөр орны рамыг мөнгөлөг саарал өнгө бүхий материалаар будаж өнгөлсөн байна. Орны толгой болон хөлний гол төмөр нь 2.5-3мм зузаантай 32мм-ээс доошгүй голчтой сайн чанарын төмрөөр, шат нь 1.5-2мм зузаантай, 22мм-ээс доошгүй голчтой төмрөөр хийгдсэн байна. Хэмжээ: L1980-2000мм x W970мм x H1680-1700мм тус тусад нь салгаж болдог, хоёр тусдаа ор болгоход орны түвшин ижил байхын дээр сайн чанарын хоорондоо холбоос бүхий хөндлөн байдлаар дэлгэгдэх боломжтой байх. Ор нь сайн чанарын хатаасан модоор хийгдсэн 20 мм-с багагүй зузаантай модон дүүргэвчтэй байна.	850
2	Дотуур байрны өрөөний сандал	Дотуур байрны өрөөний мухар сандалыг шилмүүст ба навчит төрлийн модон материалаар хийх бөгөөд сандлын тавцангын зузаан нь 15-20мм, сандлын хөлийг 40x40мм-ийн оглолтой дүнзэнцэрээр хийж, бат бэхийн шаардлага хангасан углуурга заадал гарган дээд, доод хэсгийг хөндлөн тушаануудыг цавуудан холбож, тавцанг хөлний дээд хөндлөн тушаануудад шурган бэхлэгээр бэхэлсэн байна. Мухар сандлын тавцангийн дээд ирмэг хэсгийг 10мм-р, өнцөгүүдийг 30мм-ийн дугуй хэлбэртэй хурц ирмэггүй, 4 хөлтэй байна. Мухар сандлын өнгө нь цэвэр модыг лакаар өнгөлсөн байна. Хэмжээ: L300мм x W300мм x H400-450мм	832

№

3	Дотуур байрны өрөөний ширээ	Дотуур байрны өрөөний ширээ нь хүүхэд сууж хичээл хийх зориулалттай ширээний тавцанг нягт өндөртэй 18 мм-ийн зузаантай сайн чанарын шахмал модон хавтангаар хийж зориулалтын эмжээр ирмэг хуулга материалаар өнгөлсөн байна. Уг материал нь хуурахгүй ус чийг нэвтрүүлдэггүй, халуун хүйтэнд тэсвэртэй байна. Ширээний хөлийг квадрант яндан төмөр хоолойгоор хийж хооронд нь гагнаастай эвхэгдэж хураагдах боломжтой тавцан хөлийн хэсгийг хооронд нь шурган холбоосоор хөдөлгөөнгүйгээр боож холбосон байна. Ширээний хөлийн шалтай харьцах хэсэгт ус чийгнээс хамгаалах тохирсон тагтай байна. Дотуур байрны хичээл хийх ширээний тавцан төмөр арам нь задарч угсрагдах ажлын зураг, иж бүрдэлийн жагсаалт, дагалдах сэлбэг хэрэгсэл болон зөөвөрлөж тээвэрлэхэд зориулагдсан хамгаалалтын баглаа боодолтой байна. Дотуур байрны хичээл хийх ширээний тавцан цайвар шаргал өнгөтэй, төмөр рамьг хар өнгө бүхий сайн чанарын төмрийн зориулалтын будгаар өнгөлсөн байна. Төмөр хөлийн хэмжээ: L60мм x W25мм x S1.5-2мм /ханын зузаан/, Ширээний хэмжээ: L1100мм x W600мм x H750мм	210
4	Дотуур байрны хүүхдийн хувцасны шүүгээ /4 хүүхдийн/	Хүүхдийн хувцасны шүүгээний дээд, дунд, ёроол, хөл, доод талын хаалгыг нягт өндөртэй 18 мм-ийн зузаантай сайн чанарын шахмал модон хавтангаар хийж, зориулалтын эмжээр ирмэг хуулга материалаар өнгөлсөн байна. Хувцасны шүүгээний дээд хэсэгт 300мм-ийн өндрийн хэмжээтэй малгайн тавиур, доод ёроолын хэсэгт 450мм-ийн өндрийн хэмжээний зай бүхий гутал хийх тасалгаа тавиуртай байх бөгөөд хувцас хэрэгсэл өлгөх дэгээ өлгүүртэй 4 хаалгатай хаалга бүр нь тус тусдаа бариул, мебелийн нууц цоожтой арын хэсгийг 5мм-ийн зузаантай өнгө дагуу сайн чанарын хавтангаар битүүмжилсэн байна. Хувцасны шүүгээний хавтан хаалгануудыг мебелийн нугааар их биед тогтоон угсарч эд ангиудын хоорондын угсралтыг мебелийн далд холбоосны шурган хэрэгсэлээр хөдөлгөөнгүй байхаар холбоно. Хувцасны шүүгээний хөлийн шалтай харьцах хэсэг ус, чийгнээс хамгаалах, хөндийрүүлэх зориулалттай PVC улавч хадаж өгсөн байна. Хувцасны шүүгээний эд ангиуд нь задарч угсрагдах ажлын зураг, иж бүрдэлийн жагсаалт, дагалдах сэлбэг хэрэгсэл болон зөөвөрлөж тээвэрлэхэд зориулагдсан хамгаалалтын баглаа боодолтой байна. Хувцасны шүүгээний өнгө нь цайвар шаргал өнгөтэй байна. Хэмжээ: L1600мм x W500мм x H1900мм	430
5	Багшийн ширээ	Тавцан болон хөл тэдгээрийг холбосон урд талын хаалт нь чанар, стандартын шаардлага хангасан тунгалаг лакан болон гоёлын ламинар, өнгөлгөөгөөр өнгөлсөн ДСП, МДФ, HDF шахмал модон хавтангаар, эмжээр нь PVC буюу зориулалтын хуванцар материалаар хийгдсэн байна. Уг материал нь хуурахгүй ус чийг нэвтрүүлдэггүй, халуун хүйтэнд тэсвэртэй байна. Хэмжээ: L1000мм x W600мм x H750мм. 2 ширхэг татдаг шүүгээтэй буюу ширээнээс өлгөдөг тумбочиктэй, цоожтой байна. Цайвар шаргал өнгөтэй байна. Ширээний хөлийн доод 4 талд шалнаас тусгаарлагч материалтай /шалнаас 10-15мм/, Ширээний ирмэг дугуй хэлбэртэй байна.	50
6	Багшийн сандал	Чанар, стандартын шаардлага хангасан төмөр рамтай, түшлэгтэй, түшлэг болон суудал нь зөөлөвчтэй, хөл нь хуванцар хамгаалалттай, гарын түшлэггүй хар өнгөтэй байна. L420мм x W420мм x H1-400мм x H2-900мм	50

7	6 настай хүүхдийн ор	<p>Амрах зориулалттай. Ор нь урд талаараа хамгаалалттай, байхаар тооцож шатыг орнуудын баруун гар талын хэсэгт үндсэн урт рам хэсэгт боож тогтоосон байна. Орны толгой болон хөлний төмөр хийцийг бөөрөнхий яндан хоолой төмрөөр хийж гагнаасан холбоостой байх ба урд хэсгийн 2 талын тууш хэсэг болон шатны хэсгийг профиль квадрат төмрөөр тус тус хийсэн байна. Төмөр орны хөлнүүдийн шалтай харьцах хэсэгт ус чийгнээс хамгаалах тохирсон PVC тагтай байна. Төмөр орыг угсрах угсрагдах ажлын зураг, иж бүрдлийн жагсаалт, дагалдах сэлбэг хэрэгсэл болон зөөвөрлөж тээвэрлэхэд зориулагдсан хамгаалалтын баглаа боодолтой байна. Орны толгой болон хөлний гол төмөр нь 2.5-3мм зузаантай 32мм-ээс доошгүй голчтой сайн чанарын төмрөөр хийгдсэн байна. Хэмжээ: L1980-2000мм x W970мм x H1680-1700мм. Ор нь сайн чанарын хатаасан модоор хийгдсэн 20 мм-с багагүй зузаантай модон дүүргэвчтэй байна.</p>	480
<b>НИЙТ ДҮН</b>		<b>2,902</b>	

Хянасан:

Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга



X. Тамираа

Боловсруулсан:

Ерөнхий боловсролын бодлогын удирдлага зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн



Д. Соёлмаа

Хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн



Ш. Энхтуул

— оОо —